



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 4/400

Улаанбаатар хот

Барилга байгууламж, данснаас
хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 102 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/934 дүгээр р захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2019 оны 02-07-136/1695 дугаар актаар ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороонд байрлах 49,480,453.20 /дөчин есөн сая дөрвөн зуун наян мянга дөрвөн зуун тавин гурван төгрөг хорин мөнгө/ төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг актлан, данс бүртгэлээсээ хасч, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч Н.Уранчимэгт зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 1,500,000 /нэг сая таван зуун мянган/ төгрөгийн хөрөнгийг борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Рэнцэнбямбад даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ҮНЭНБАТ



115050000951

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын
2020 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн
тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГЫН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	Агуулахын барилга	60	1960	ш	1	10,495,864.69	1,749,310.80	8,746,553.89
2	Гараашийн барилга	60	1960	ш	1	1,697,909.06	424,477.32	1,273,431.74
3	Конторын барилга	60	1960	ш	1	37,286,679.45	9,321,669.84	27,965,009.61
Нийт					3	49,480,453.20	11,495,457.69	37,984,995.24